



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн  
2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** СЭА-2023/06/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
	Утас: 7036-3040      Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a>
	Аудитын менежер: Б.Батмөнх
	Утас: 7036-3036      Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a>
	Аудитор: Т.Одсүрэн
	Утас: 7036-2442      Цахим хаяг: <a href="mailto:odsurent@audit.gov.com">odsurent@audit.gov.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

<b>1. АУДИТЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	10
3.5.1 Мөнгөн хөрөнгө .....	11
3.5.2 Авлага .....	11
3.5.4 Үндсэн хөрөнгө .....	13
3.5.5 Өр төлбөр .....	14
3.5.6 Засгийн газрын хувь оролцоо .....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	15
3.5.1 Төсвийн төлөвлөлт .....	17
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .....	17
3.5.3 Нэмэлт төсөв .....	19
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	19
4.1 Ерөнхий зүйл .....	19
4.2 Материаллаг байдал .....	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	21
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	21
4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд .....	22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	23
4.5.1 Завсрын аудитын талаар .....	23
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн .....	23
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	24
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	25
5.1 Төлбөрийн акт .....	25
5.2 Албан шаардлага .....	26
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	28

## Товчилсон үгийн жагсаалт

<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>ЕБС</b>	Ерөнхий боловсролын сургууль
<b>ЗГ</b>	Засгийн газар
<b>ЗДНХ</b>	Засаг даргын нөөц хөрөнгө
<b>ЗДТГ</b>	Засаг даргын тамгын газар
<b>ИТХ</b>	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
<b>МУЕА</b>	Монгол улсын ерөнхий аудитор
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>ОНЕО</b>	Орон нутгийн ерөнхий орлого
<b>ОНХС</b>	Орон нутгийн хөгжлийн сан
<b>ТАХ</b>	Төсөл арга хэмжээ
<b>ТБОНӨБАҮХА</b>	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
<b>ТТЗ</b>	Төсвийн төвлөрүүлэн захирагч
<b>УСНББОУС</b>	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
<b>ХНХС</b>	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
<b>ХХААХҮС</b>	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
<b>ХХОАТ</b>	Хувь хүний орлогын албан татвар
<b>ХХС</b>	Хоршоо хөгжүүлэх сан
<b>ЭМДС</b>	Эрүүл мэндийн даатгалын сан
<b>ЭМТ</b>	Эрүүл мэндийн төв
<b>ЭМЯ</b>	Эрүүл мэндийн яам
<b>ЭБАТ</b>	Эрх бүхий албан тушаал



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЖАВХЛАНТ  
СУМЫН ЗАСАГ ДАРГА,  
Ц.ДАРХАНБААТАР ТАНАА

2023.03.25 № 00А/2023/06-НАСГА-ТТЗ

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Жавхланта сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Жавхланта сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Жавхланта сумын төсвийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтээс татварын ба татварын бус орлогын бүрдүүлэлт 6.5 хувиар дутуу биелсэн, төсвийн гүйцэтгэл 86.2 хувьтай тайлагнагдсан нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний гүйцэтгэл 50.7 хувь нь хэрэгжээгүйгээс голлон шалтгаалж нийт төсөв 13.8 хувиар хэмнэгдсэн байна.

**Аудитын гол асуудал**

Жавхланта сумын төсвийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 35.1 хувь буюу 391,106.0 мянган төгрөгийг

018020365

цалин хөлс болон нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд хангамж, бараа материалын зардалд 37,994.7 мянган төгрөг, нормативт зардалд 364,994.7 мянган төгрөг, тавилга эд хогшил, урсгал засварын зардалд 51,255.4 мянган төгрөг бараа үйлчилгээний бусад зардалд 72,544.1 мянган төгрөг, өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжид 18,561.2 мянган төгрөг, эргэн төлөгдөх зээлд 30,000.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 137,053.8 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг болон сумын эрүүл мэндийн төвийг улсын төсвийн байгууллага болгосонтой холбоотойгоор төвийн төвлөрүүлэн захирагчийн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл буурсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>502,803.6</b>	<b>369,128.5</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>104,242.5</b>	<b>200,713.5</b>
33	<b>АВЛАГА</b>	<b>216,194.6</b>	<b>120,306.4</b>
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	-
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>182,366.5</b>	<b>28,986.6</b>
36	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	-	<b>19,122.0</b>
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,674,673.7</b>	<b>1,591,455.0</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,674,673.7</b>	<b>1,591,455.0</b>
39100	Газар	-	-
39200	Биет хөрөнгө	3,659,680.0	1,587,367.8
39300	Биет бус хөрөнгө	14,993.6	4,087.2
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,177,477.3</b>	<b>1,960,583.5</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>91,638.3</b>	-
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>91,638.3</b>	-
41300	Өглөг	91,638.3	-
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,085,839.0</b>	<b>1,960,583.5</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>4,085,839.0</b>	<b>1,960,583.5</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,314,337.2	339,508.6
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	-	339,508.6
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,590,977.6</b>	<b>1,379,778.1</b>
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,180,524.2	241,296.8
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,177,477.3</b>	<b>1,960,583.5</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,141,766.7</b>	<b>1,904,216.8</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>92,431.1</b>	<b>310,057.5</b>
110	Орлогын албан татвар	20,315.6	146,919.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	20,315.6	146,919.3
113	Хөрөнгийн албан татвар	44,306.4	88,212.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	27,809.1	74,925.4
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>593,229.9</b>	<b>227,499.4</b>
120	Нийтлэг татварын бус орлого	593,229.9	227,499.4
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,456,105.7</b>	<b>1,366,659.9</b>
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,705,788.2</b>	<b>1,142,537.7</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,705,788.2</b>	<b>1,142,537.7</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,624,180.0</b>	<b>1,123,976.5</b>

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,448,781.7	349,243.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	183,884.1	42,298.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	272,605.3	368,835.0
2104	Хангамж, бараа материалын зардал	85,134.9	40,876.7
2105	Нормативт зардал	235,591.8	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,142.4	55,737.3
2107	Томилолт, зочны зардал	1,933.0	3,834.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,197.4	7,175.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	328,909.4	255,975.7
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>81,608.2</b>	<b>18,561.2</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>435,978.5</b>	<b>761,679.1</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>206,432.7</b>	<b>2,884,590.3</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>229,545.8</b>	<b>(2,122,911.2)</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
<b>1</b>	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>3,859,039.60</b>	<b>3,859,039.60</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(2,746.4)	(2,746.4)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,856,293.2	3,856,293.2
9	Тайлант үеийн үр дүн	229,545.8	229,545.8
<b>10</b>	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>4,085,839.0</b>	<b>4,085,839.0</b>
<b>11</b>	<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>4,085,839.0</b>	<b>4,085,839.0</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(2,344.3)	(2,344.3)
<b>13</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>4,083,494.6</b>	<b>4,083,494.6</b>
19	Тайлант үеийн үр дүн	(2,122,911.2)	(2,122,911.2)
<b>20</b>	<b>2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>1,960,583.5</b>	<b>1,960,583.5</b>

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,556,781.0</b>	<b>1,728,728.4</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>92,431.1</b>	<b>310,057.5</b>
110	Орлогын албан татвар	20,315.6	146,919.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	20,315.6	146,919.3
113	Хөрөнгийн албан татвар	44,306.4	88,212.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	27,809.1	74,925.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	3,184.9	4,723.1
1181	Газрын төлбөр	18,307.9	65,971.4

1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	6,316.3	4,231.0
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>102,196.7</b>	<b>52,011.0</b>
120	Нийтлэг татварын бус орлого	102,196.7	52,011.0
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,362,153.3</b>	<b>1,366,659.9</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,354,026.1</b>	<b>962,399.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,354,026.1</b>	<b>962,399.0</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,272,417.9</b>	<b>943,837.8</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,421,691.6	349,666.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	182,360.7	43,175.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	272,227.0	368,835.0
2104	Хангамж, бараа материалын зардал	68,787.8	38,271.6
2105	Нормативт зардал	199,640.4	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,464.4	55,783.9
2107	Томилолт, зочны зардал	1,933.0	3,834.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,144.6	7,175.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,168.2	77,095.2
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>81,608.2</b>	<b>18,561.2</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>202,755.0</b>	<b>766,329.4</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>131,641.7</b>	<b>639,858.4</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>131,641.7</b>	<b>639,858.4</b>
<b>2200</b>	Дотоод эх үүсвэрээр	131,641.7	639,858.4
<b>2260</b>	Гадаад эх үүсвэрээр	-	-
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(131,641.7)</b>	<b>(639,858.4)</b>
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>(4,000.0)</b>	<b>(30,000.0)</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>4,000.0</b>	<b>30,000.0</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>67,113.3</b>	<b>96,471.0</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	37,129.2	104,242.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	104,242.5	200,713.5

## 2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,291,344.2</b>	<b>1,113,542.4</b>	<b>177,801.8</b>	<b>86.2</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>953,243.9</b>	<b>946,488.6</b>	<b>953.2</b>	<b>99.3</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>934,681.1</b>	<b>927,927.4</b>	<b>934.7</b>	<b>99.3</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	350,366.1	347,930.2	350.4	99.3

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,796.0	43,175.8	43.8	98.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	366,812.6	364,994.7	366.8	99.5
2104	Хангамж, бараа материалын зардал	37,149.2	37,017.0	37.1	99.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,970.0	51,255.4	53.0	96.8
2107	Томилолт, зочны зардал	3,858.2	3,834.8	3.9	99.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,183.4	7,175.4	7.2	99.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,545.6	72,544.2	72.5	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>18,562.8</b>	<b>18,561.2</b>	<b>18.6</b>	<b>100.0</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,562.8	18,561.2	18.6	100.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>278,100.3</b>	<b>137,053.8</b>	<b>278.1</b>	<b>49.3</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>60,000.0</b>	<b>30,000.0</b>	<b>60.0</b>	<b>50.0</b>
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,291,344.2</b>	<b>1,111,344.3</b>	<b>1,291.3</b>	<b>86.1</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,185,865.6</b>	<b>1,074,828.3</b>	<b>1,185.9</b>	<b>90.6</b>
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>105,478.6</b>	<b>36,516.0</b>	<b>105.5</b>	<b>34.6</b>
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	85,167.5	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	82,969.4	-	-
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>94.0</b>	<b>48.0</b>	<b>46.0</b>	<b>51.1</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2.0</b>	<b>2.0</b>	<b>-</b>	<b>100.0</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>46.0</b>	<b>23.0</b>	<b>23.0</b>	<b>50.0</b>
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>46.0</b>	<b>23.0</b>	<b>23.0</b>	<b>50.0</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>530,494.3</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>30,853.5</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>19,074.2</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,736.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,840.3
2104	Хангамж, бараа материалын зардал	1,348.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,598.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,551.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,779.3</b>
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,779.3
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>499,640.8</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	499,640.8
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>530,494.3</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	530,494.3
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0.0</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Жавхлант сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг *“Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх, боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлж, мэргэшсэн тогтвортой, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх.”* гэж тодорхойлжээ.

Дээрх эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- ЗГ-ын 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2022 оны 194 дүгээр тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт”-д өөрчлөлт оруулсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.
- ХХААХҮС-ын 2021 оны А/361 дугаар тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлтэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам” хэрэгжиж ирсэн.
- ЗГ-ын 2021 оны 402 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга, хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам” хэрэгжиж эхэлсэн.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жавхлант сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Жавхлант сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан “*Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг*”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Жавхлант сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “*Төсвийн ерөнхийлөн захирагчийн*

болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,216,93.8 мянган төгрөгөөр буюу 53.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	104,242.5	200,713.5	96,471.0
Авлага	216,194.6	120,306.4	(95,888.2)
Бараа материал	182,366.5	28,986.6	(153,379.9)
Нөөцийн бараа	-	19,122.0	-
Үндсэн хөрөнгө	3,674,673.7	1,591,455.0	(2,083,218.7)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,177,477.3</b>	<b>1,960,583.5</b>	<b>(2,216,893.8)</b>
Өр төлбөр	91,638.3		(91,638.3)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,085,839.0	1,960,583.5	(2,125,255.5)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>4,177,477.3</b>	<b>1,960,583.5</b>	<b>(2,216,893.8)</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансад бөгөөд өөрчлөлтийг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 104,242.5 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 200,716.5 мянган төгрөг болж, 96,474.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	104,242.5	200,716.5	96,474.0
<b>Дүн</b>	<b>104,242.5</b>	<b>200,716.5</b>	<b>96,474.0</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан ОНЕО-ын дансанд 117,774.1 мянган төгрөг, ОНХС-ийн дансанд 8,526.6 мянган төгрөг, ХХС-ийн дансанд 74,442.8 мянган төгрөг зэрэг нийт 200,716.5 мянган төгрөг төрийн сангийн харилцах дансанд байршиж байна.

### 3.4.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 216,194.7 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 120,306.4 мянган төгрөг болж, 95,888.3 мянган төгрөгөөр буюу 44.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	30.2	192.2	162.0
Зээлийн хүүгийн авлага	4,282.8	5,118.8	836.0
Байгууллагаас авах авлага	93,952.5	968.2	(92,984.3)
Хувь хүмүүсээс авах авлага	2,293.4	2,293.4	-
Зээлийн авлага	115,635.8	111,733.8	(3,902.0)
<b>Дүн</b>	<b>216,194.7</b>	<b>120,306.4</b>	<b>(95,888.3)</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Авлага дансны эцсийн үлдэгдэл 95,888.3 мянган төгрөгөөр буурсан нь цалингийн тооцооллыг хянаагүйгээс НДШ, ХХОАТ-т ИТХ-аас 192.2 мянган төгрөг, ЗДТГ-аас 968.2 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн, ХХС-аас олгосон зээлийн авлага 30,000.0 мянган төгрөг, зээлийн хүүгийн авлага 2,699.8 төгрөгөөр нэмэгдэж, оны эхний үлдэгдлээр тайлагнагдсан сумын ЭМТ-ийн ЭМДС-аас авах төлбөртэй үйлчилгээний 93,952.4 мянган төгрөг, ажилчидтай холбоотой 30.2 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтийн 35,765.9 мянган төгрөгийн авлага тус тус буурснаас шалтгаалсан байна.

**Аудитын илрүүлэлт:**

Жавхлант сумын ТТЗ-ийн харьяаны дараах байгууллагуудын төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулаагүй, авлага барагдуулах арга хэмжээ аваагүйгээс дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- ОНЕО-ын дансанд бүртгэлтэй 2010-2011 онд 5 иргэнд олгосон итгэлийн зээлийн төлөгдөөгүй үлдэгдэл 2,293.4 мянган төгрөг /тооцоо нийлсэн акт байхгүй, эзэн тодорхойгүй/-ийн хугацаа хэтэрсэн итгэлийн зээлийн авлага бүртгээгдсэн бөгөөд авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй.
- ИТХ: Цалингийн тооцооллыг хянаагүйгээс НДШ-д 189.8 мянган төгрөг, ХХОАТ-ын 2.4 мянган төгрөг зэрэг нийт 192.2 мянган төгрөгийг илүү шилжүүлж авлага үүсгэсэн.
- ЗДТГ: Цалингийн тооцооллыг хянаагүйгээс НДШ-д 968.2 мянган төгрөгийг илүү шилжүүлэн авлага үүсгэсэн.

**3.4.3 Бараа материал**

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 182,366.5 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 28,986.6 мянган төгрөг болж, 153,379.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	1,845.5	7,529.4	(34,316.1)
Эм боох материал	11,665.1	-	(11,665.1)
Бэлэн бүтээгдэхүүн	13,770.0	-	(13,770.0)

Бичиг хэргийн материал	8,966.2	2,376.7	(6,589.5)
Аж ахуйн материал	92,869.0	17,843.1	(75,025.9)
Сэлбэг хэрэгсэл	1,355.0	324.0	(1,031.0)
Барилгын засварын материал	4,266.1	-	(4,266.1)
Хүнсний материал	2,416.3	-	(2,416.3)
Бусад хангамжийн материал	5,213.3	913.4	(4,299.9)
Нөөцийн бараа	0	19122.0	(19.12260)
<b>Дүн</b>	<b>182,366.5</b>	<b>28,986.6</b>	<b>(153,379.9)</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Материалын дансны үлдэгдэл 153,379.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 208,725.0 мянган төгрөгийн барааг худалдан авч, хандив, тусламжаар 3,000.0 мянган төгрөгийн материал үнэ төлбөргүй хүлээн авсан бөгөөд 94,669.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, ОНХС-аас ЗДТГ-т хоорондын тооцоогоор 115,053.8 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлсэн, сургууль, цэцэрлэг, соёлын төв зэрэг байгууллагуудын 155,381.2 мянган төгрөгийн бараа материалыг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

### Аудитын илрүүлэлт:

Жавхлант сумын ТТЗ-ийн харьяаны дараах байгууллагууд нь бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Үүнд:

- ЗДТГ төлбөрийн цахим баримтыг бөөн дүнгээр бүртгэсэн 8,450.8 мянган төгрөг,

#### Хүснэгт 5. Нөөцийн барааны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Нөөцийн бараа	-	19,122.0	(19.122.0)
<b>Дүн</b>	-	<b>19,122.0</b>	<b>(19.122.0)</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант онд нөөцийн барааны данс 19,122.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь ЗДНХ-өөс өвлийн бэлтгэл ажлын хүрээнд /Хатансэлэнгэ орхон ХХК, Баянжаргалан хайрхан ХХК, Гилдээ ХХК/-аас 3187 боодол өвс худалдан авч нөөц үүсгэснээс шалтгаалсан байна.

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 4,799,362.3 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 2,448,545.6 мянган төгрөг болж, 2,350,816.7 мянган төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 6. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	2,765,891.8	566,749.6	(2,199,142.2)
Авто-тээврийн хэрэгсэл	147,740.8	73,270.0	(74,470.8)

Машин тоног төхөөрөмж(компьютер)	453,108.6	136,944.5	(316,164.1)
Тавилга, аж ахуйн эд хогшил	216,644.4	38,779.8	(177,864.6)
Дуусаагүй барилга байгууламж	50,000.0	-	(50,000.0)
Бусад үндсэн хөрөнгө	1,146,068.5	1,625,572.7	479,504.2
Программ хангамж	7,955.0	4,240.0	(3,715.0)
Бусад биет бус хөрөнгө	11,953.2	2,989.0	(8,964.2)
<b>Дүн</b>	<b>4,799,362.3</b>	<b>2,448,545.6</b>	<b>(2,350,816.7)</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл **2,350,816.7** мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 502,804.6 мянган төгрөг /аймгийн ОНХС-аас эрх шилжүүлсэн хөрөнгийн эх үүсвэрээр хийгдсэн хатуу хучилттай зам, агаар цахилгааны шугам, дэд станц, замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрэлтүүлэг/-ийн хөрөнгө худалдан авсан, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 115,053.8 мянган төгрөгийн гудамжны гэрэлтүүлэг, хогийн цэгийн хашаа, ногоон байгууламжийн хашаа, тоглоомын талбай, зэргийг шилжүүлэн авсан, 2021 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 90,500.5 мянган төгрөгийн 2 худгийн барилгыг бусад үндсэн хөрөнгөнд бүртгэж, аймгийн ИТХ-ын 2022 оны 39 дүгээр тогтоолоор 22,208.3 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг акталж, сургууль, цэцэрлэг, соёлын төв зэрэг байгууллагуудын 3,036,967.3 мянган төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр холбогдох яамдуудад шилжүүлсэн зэргээс шалтгаалсан байна.

### 3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөр дансны 91,638.3 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй тайлагнагдсан байсан бол тайлант оны эцэст үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Хүснэгт 7. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	28,394.5	-	(28,394.5)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	63,243.8	-	(63,243.8)
<b>Дүн</b>	<b>91,638.3</b>	<b>-</b>	<b>(91,638.3)</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Сумын ЭМТ-ийн ЭМДС-ийн санхүүжилтийн дутуугаас өмнөх онд үүссэн цалингийн өглөг **28,394.5** мянган төгрөг, бараа үйлчилгээний зардлын өглөг **63,243.8** мянган төгрөгийн өр төлбөр байсан бол тайлант онд тус газар нь ЭМЯ-нд харьяалагдах болсноор үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,085,839.0 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 1,959,615.2 мянган төгрөг болж, 2,126,223.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,314,337.2	339,508.6	(974,828.6)
Хуримтлагдсан үр дүн	1,590,977.6	1,379,778.1	(211,199.5)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,180,524.2	241,296.7	(939,227.5)
<b>Дүн</b>	<b>4,085,839.0</b>	<b>1,960,583.4</b>	<b>(2,125,255.6)</b>

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл буурсан нь Соёлын төв, ЕБС, цэцэрлэг, сумын ЭМТ гэсэн байгууллагуудыг бүтцийн өөрчлөлтөөр холбогдох яамдуудад шилжүүлснээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын 2022 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 19 дүгээр тогтоолоор Жавхлант сум нь тайлант онд 321,627.8 мянган төгрөгийн татварын орлого, 35,000.0 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт 356,627.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас 2022 оны төсөвт тодотгол хийх 19 дүгээр тогтоолоор татварын орлогыг 313,127.8 мянган төгрөг, татварын бус орлогыг 35,000.0 мянган төгрөг болгон өөрчилсөн ба гүйцэтгэлээр 325,552.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөний биелэлт 93.5 хувьтай байна.

#### Хүснэгт 9. Төвлөрүүлэх орлого

				/мянган төгрөг/	
д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	115,000.0	121,775.8	(6,775.8)	105.9
2	Үйл ажиллагааны орлого	9,100.0	13,383.3	(4,283.3)	147.1
3	Хөрөнгийн орлого	8,362.9	9,468.4	(1,105.5)	113.2
4	Хөрөнгө борлуулсны орлого	6,400.0	2,291.8	4,108.2	35.8
5	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	3,700.0	2,511.3	1,188.7	67.9
6	Бууны албан татвар	566.0	600.0	(34.0)	106.0
7	Малд ногдуулах албан татвар	104,184.4	85,101.5	19,082.9	81.7
8	Улсын тэмдэгтийн хураамж	2,200.0	3,207.1	(1,007.1)	145.8
9	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1,500.0	1,516.0	(16.0)	101.1
10	Газрын төлбөр	24,182.5	22,317.2	1,865.3	92.3
11	Дуудлага худалдаа	31,300.0	43,654.2	(12,354.2)	139.5
12	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	132.0	0.0	132.0	-
13	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	6,500.0	4,231.0	2,269.1	65.1
	<b>Татварын орлогын дүн</b>	<b>313,127.8</b>	<b>310,057.5</b>	<b>3,070.3</b>	<b>99.0</b>
14	Торгуулийн орлого	20,000.0	13,580.1	6,420.0	67.9
15	Бусад орлого	15,000.0	1,915.0	13,085.0	12.8

Татварын бус орлогын дүн	35,000.0	15,495.1	19,505.0	80.7
Дүн	348,127.8	325,552.6	22,575.2	93.5

Орлогын төлөвлөгөө 22,575.2 мянган төгрөгөөр тасарсан нь хөрөнгө борлуулсны орлого 4,108.2 мянган төгрөг, үл хөдлөх хөрөнгийн албан татвар 1,188.7 мянган төгрөг, малын тоо толгойн албан татвар 19,082.9 мянган төгрөг, газрын төлбөр 1,865.4 мянган төгрөг, ан амьтны нөөц ашигласны төлбөр 132.0 мянган төгрөг, хүү торгуулийн орлого 6,420.0 мянган төгрөгөөр, бусад орлого 13,085.0 мянган төгрөгөөр тус тус тасарсантай холбоотой байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний төлөвлөгөөнөөс давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

### **Давсан орлого**

- *ЗГ-ын 2022 оны 107, 192, 194 дүгээр тогтоолуудаар төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор цалин хөлс,шагнал, урамшуулал болон түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос суутган тооцох татварын орлого нэмэгдсэн.*
- *Газрын дуудлага худалдааны орлого 39.5 хувиар давсан нь газрын дуудлага худалдааг сайн зохион байгуулснаас шалтгаалсан.*
- *Үйл ажиллагааны орлого 4,238.3 мянган төгрөгөөр давсан нь иргэн аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны орлогоос суутган тооцсон татварын төвлөрүүлэлтээс шалтгаалсан байна.*

### **Тасарсан орлого:**

- *Хөрөнгө борлуулсны орлого 35.8 хувийн биелэлтэй байгаа нь иргэд, аж нэгжээс хөрөнгийн борлуулалт хийгдэхгүй байгаагаас,*
- *Үл хөдлөх хөрөнгийн албан татвар 67.5 хувьтай байгаа нь 3 аж ахуйн нэгж татвараа төлөөгүйтэй холбоотой байна.*
- *Малын тоо толгойн татварын орлогыг биелэлт 81.7 хувьтай байгаа нь малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбоотой хугацаа алдсанаас шалтгаалсан,*
- *Байгалийн ургамал ашигласны төлбөр 65.1 хувийн биелэлттэй байгаа нь тухайн жилийн ургамлын гарц, зөвшөөрөл хүссэн иргэдийн хүсэлт буурснаас шалтгаалсан.*
- *Бусад орлогын биелэлт 12.7 хувьтай байгаа нь аймгаас орлогын төлөвлөгөөг батлахдаа сумаас ирүүлсэн төсвийн саналыг үндэслэлгүйгээр, хэт өндрөөр баталснаас.*
- *Хүү, торгуулийн орлого иргэд хугацаандаа төлбөрөө барагдуулаагүйгээс тус тус шалтгаалсан байна.*

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Жавхлант сумын ТТЗ-ийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,290,500.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,290,500.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өргөн барьсан төсвийн төслийг сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор нийт зарлагыг 1,344,004.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын төсөвт хийгдсэн тодотгол болон зохицуулалтаар дараах өөрчлөлтүүд орж сумын төсөв **1,291,344.2** мянган төгрөгөөр эцэслэн батлагдсан байна. Үүнд:

**Сумын ИТХ-ын 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 19 дугаар тогтоолоор:**

#### Төсвийн орлогын өөрчлөлт:

- *Газрын дуудлага худалдааны орлогыг 11,300.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, улсын тэмдэгтийн хураамжийг 19,800.0 мянган төгрөгөөр, аймгийн санхүүгийн дэмжлэгийг 44,159.9 мянган төгрөгөөр тус тус бууруулсан.*

#### Төсвийн зарлагын өөрчлөлт:

- *ЗГ-ын 2022 оны 194 дүгээр тогтоолын хэрэгжилттэй холбоотойгоор ЗДТГ-ын цалингийн зардлыг 9,955.0 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 1,243.9 мянган төгрөгөөр,*
- *Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс урсгал засварын зардал /хогийн машины засвар/-ыг 15,000.0 мянган төгрөгөөр,*
- *Засаг даргын нөөц хөрөнгийг 16,400.0 мянган төгрөгөөр,*
- *Багийн засаг даргын үйл ажиллагааны урсгал зардлыг 1,020.0 мянган төгрөгөөр,*
- *ИТХ-ын төсвийг ЗГ-ын 2021 оны 402 дугаар тогтоолын дагуу төлөөлөгчдийн урамшууллын зардлыг 21,262.5 мянган төгрөгөөр,*
- *Соёлын төвийн тогтмол зардлыг 2,487.4 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, орон нутгаас санхүүжих улсын төсвийн байгууллага /ЭМТ 23,261.9 мянган төгрөг, ЕБС 54,103.1 мянган төгрөг, цэцэрлэг 42,063.7 мянган төгрөг/-ын тогтмол зардлыг 119,428.7 мянган төгрөгөөр бууруулсан байна.*

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 25 дугаар тогтоолоор аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 751,520.4 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 130,377.3 мянган төгрөгөөр тус тус баталсан бол дээрх тогтоолыг үндэслэн төсвийн төвлөрүүлэн захирагчийн өргөн барьсан төслийг сумын

ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор сумын төсвийн орлогыг 356,627.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 500.0 мянган төгрөг, ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 43,538.6 мянган төгрөг, ХХС-ийн 61,440.0 мянган төгрөгийн зэрэг нийт 1,344,004.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын “Аймгийн 2022 оны тодотгосон төсөв батлах тухай” 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 55 дугаар тогтоолоор тус суманд аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 44,159.9 мянган төгрөгөөр, татварын орлогыг 8,500.0 мянган төгрөгөөр бууруулан баталсан байна. Дээрх тогтоолыг үндэслэн сумын төсөвт хийгдсэн тодотгол болон зохицуулалтаар сумын төсвийг **1,291,344.2** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 1,291,344.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 951,793.9 мянган төгрөгийг урсгал зардалд, 278,100.3 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 61,440.0 мянган төгрөгийг ХХС-ийн эргэн төлөгдөх зээлд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт зардлын 707,360.5 мянган төгрөгийг аймгаас авах санхүүгийн дэмжлэгээс, 348,127.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 43,538.6 мянган төгрөгийг ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс, 130,377.3 мянган төгрөгийг аймгийн ОНХС-аас, 61,440.0 мянган төгрөгийг ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс, 500.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос, санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр аймгаас авах санхүүгийн дэмжлэг 707,360.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 325,552.6 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 750.0 мянган төгрөг, ОНХС-аас 130,377.3 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлт 35,765.9 мянган төгрөг зэрэг нийт **1,199,806.3** мянган төгрөгийн санхүүжилтийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,113,542.4** мянган төгрөг буюу 86.2 хувьтай тайлагнагдсан нь орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийг гүйцэтгэлээр олгож, хэмнэлтийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 350.4 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 43.8 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 366.8 мянган төгрөгөөр, хангамжийн материалын зардал 37.1 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 53.0 мянган төгрөгөөр, томилолтын зардал 3.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 7.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 72.5 мянган төгрөг, тэтгэмж, урамшуулал 18.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын төсвийн хөрөнгө оруулалт батлагдаагүй бөгөөд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 17 төсөл, арга хэмжээнд 278,100.3 төгрөгийн санхүүжилт

олгохоор батлагдсанаас гүйцэтгэлээр 137,053.8 мянган төгрөгийн санхүүжилт олгож үлдэгдлийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн ЗДНХ-өөс 14,984.8 мянган төгрөг, аймгийн ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр эрх шилжүүлсэн төсөл арга хэмжээний зардалд дээд шатны төсвийн захирагчдаас 504,459.2 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 11,050.3 мянган төгрөг зэрэг нийт 530,494.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Үүнээс цалин хөлсөнд 1,736.0 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 3,840.3 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 1,348.4 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 7,598.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 4,551.0 мянган төгрөг, зэрэг, хөрөнгийн зардалд 499,640.8 мянган төгрөг зэрэг нийт 518,715.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж, үлдэгдэл 11,779.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын төсвийн төвлөрүүлэн захирагч цаашид */Жавхлант сумын ТТЗ гэх/-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.*

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулалгүйгээр урьдчилгаа санхүүжилт олгосон, захиргааны актыг боловсруулахдаа эрх зүйн үндэслэлийг буруу сонгосон, ЭБАТ-ын нэмэгдлийг хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагчийн тоонд харгалзуулалгүйгээр нэмэгдэл олгосон, он дамнасан эзэн холбогдогч нь тодорхойгүй авлагыг барагдуулах зөрчлүүдэд өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Одсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Т.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Жавхлант сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/31 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үзлээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,705,488.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 27,054.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 18,938.4 мянган төгрөгөөр урьдчилан тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан ЕБС, цэцэрлэг, сумын ЭМТ зэрэг байгууллагуудын санхүүгийн тайлан тус тусын яаманд нэгтгэгдсэн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангийн нийт зардал болох 1,528,014.9 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон **15,528.0** мянган төгрөгөөр тогтоолоо.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлийг аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн “Үүрэг чиглэл өгөх тухай” 01/633 дугаар албан бичгийн хүрээнд төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, өр авлага үүсгэхгүй ажиллах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, ЗДНХ-ийг зориулалтын дагуу зарцуулах, ТБОНӨХБАҮХА тухай хууль болон босго үнийн журмыг мөрдөн ажиллах, аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах гэх мэт нийт 18 төрлийн чиглэл хүргүүлсний дагуу дараах арга хэмжээг авч ажилласан байна. Үүнд:

- Төсвийн зарлагын чиглэлээр төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын батлагдсан төсвийн гүйцэтгэлд хяналт тавин ажилласан.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 137,100.0 мянган төгрөгийн иргэдийн санал авч эрэмбэлээгүй, төсвийн тооцоо судалгаагүй 11 төсөл арга хэмжээг аудитаас өгсөн зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн тайлант онд хэрэгжүүлээгүй.
- Төсвийн хэмнэлтийн горимд шилжсэнтэй холбогдуулан аймгаас өгөх санхүүгийн дэмжлэгийг 44,159.9 мянган төгрөгөөр бууруулсан тул төсвийн тодотгол, зохицуулалтаар төсвийн зардлыг орлогын эх үүсвэртэй уялдуулан 52,659.9 мянган төгрөгөөр бууруулсан.
- ЗДТГ-аас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-нд захиалагчийн хяналтын зардлын 1,317.3 мянган төгрөгийг хэмнэлтэд тооцон ОНХО-ын дансанд татан төвлөрүүлсэн гэх мэт.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд сумын ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалтыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

*Хүснэгт 10. ТТЗ болон харьяа байгууллагуудын шилэн дансны мэдээлэл байршуулалт*

Үзүүлэлт	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
Засаг дарга	140	140	0	0
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	166	140	15	11
Засаг даргын тамгын газар	166	129	39	2
<b>Дүн</b>	<b>472</b>	<b>409</b>	<b>54</b>	<b>13</b>

*Эх сурвалж: шилэн дансны цахим хуудас*

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйн улмаас тайлант онд давтан гаргасан ТТЗ-ийн түвшинд нийт давхардсан тоогоор мэдээлбэл зохих 472 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 409, хугацаа хоцроосон 54, огт мэдээлээгүй 13 мэдээлэл байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.10,

Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ... бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.2 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ” гэж заасны дагуу холбогдох албан тушаалтнуудад сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

1. Засаг захиргаа нутаг дэвсгэр түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь “Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын асуудлаар Хурлын дарга захирамж гаргана.” гэсэн заалтыг үндэслэн сумын ИТХ-ын дарга нь 2022 оны 03, 05, 06, 07, 08, 09 дугаар захирамжуудаар нийт **890.0** мянган төгрөгийн тусламж, дэмжлэг олгох шийдвэр гаргасан байна.

Энэ нь Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4 дэх “Ажлын албаны үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Хурлын нарийн бичгийн дарга тушаал гаргана”, 55.1 дэх “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төсөвтэй байх бөгөөд төсвийг Хурлын нарийн бичгийн дарга захиран зарцуулна” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: ИТХ-ын төсвийг ИТХ-ын нарийн бичгийн дарга захиран зарцуулж байх зөвлөмж өгөв.

2. Илрүүлэлт: Сумын ИТХ-ын нарийн бичгийн даргад олгож буй ЭБАТ-ийн нэмэгдлийг сумын ИТХ-ын гишүүдийн мэдүүлэгч гаргагчийн тоонд харгалзуулан үндэслэлтэй бус буюу сарын 30.0 хувиар тогтоосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1. “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.2.6. “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” аймгийн Засаг даргын 2022 оны Б/14 дүгээр захирамжаар баталсан” нэмэгдэл олгох журамтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: ИТХ-ын Нарийн бичгийн даргын ЭБАТ-ын нэмэгдлийн хэмжээг аймгийн Засаг даргын 2022 оны Б/14 дүгээр захирамжид заасан мэдүүлэг гаргагчийн тоонд тохирох хувь хэмжээгээр олгох зөвлөмж өгөв.

3. Илрүүлэлт: ОНХС-ийн хөрөнгөөр гүйцэтгэсэн төсөл арга хэмжээг гүйцэтгэгч талтай гэрээ байгуулахдаа урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулалгүйгээр 30-70 хувиар урьдчилгаа төлбөр олгосон байна. Үүнд:

- *Мон жим трейд ХХК-тай байгуулсан “Ногоон байгууламжийн хашаа нэмэгдүүлэх”, төсөл арга хэмжээний урьдчилгаа санхүүжилтийг 70 хувиар олгохоор тооцож нийт 14,000.0 мянган төгрөг,*
- *Сайжрах шилтгээн ХХК-тай байгуулсан “Сумын төвийн гэрэлтүүлэг нэмэгдүүлэх” төсөл арга хэмжээний урьдчилгаа санхүүжилтэд 30 хувь буюу 14,822.7 мянган төгрөг,*
- *Баян Жаргалан хайрхан ХХК-тай байгуулсан “Хогийн цэгийн хашааг нэмэгдүүлэх” төсөл арга хэмжээний урьдчилгаа санхүүжилтэд 70 хувь буюу 14,000.0 мянган төгрөг,*
- *Васт сайз констракшн ХХК-тай байгуулсан “Төвлөрсөн халаалтын зураг төсөв” хийлгэх төсөл арга хэмжээнд 17,000.0 мянган төгрөг зэрэг нийт 59,822.7 мянган төгрөгийн урьдчилгааг тус тус олгосон байна.*

Энэ нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь “Захиалагч урьдчилгаа төлбөрийн дүнтэй тэнцүү хэмжээтэй гүйцэтгэгчийн ирүүлсэн энэ хуулийн 20.2-т заасан баталгааг үндэслэн урьдчилгаа төлбөр төлнө”, Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 41.1-т заасан “Урьдчилгаа төлбөр олгохгүй” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлэх ажил үйлчилгээг холбогдох хууль тогтоомж, тендерийн баримт бичигт заасан шалгуурт нийцүүлэн зохион байгуулж, урьдчилгаа төлбөр олгох тохиолдолд урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулж байх зөвлөмж өгөв.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй **18,647.8** мянган төгрөгийн зөрчилд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 10. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	4,936.80	1	4,936.80	100.0
Зөвлөмж	2	56,125.10	1	990.9	50.0
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>61061.9</b>	<b>2</b>	<b>5927.7</b>	<b>75.0</b>

Эх сурвалж: Жавхланта сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Өмнөх аудитаар өгсөн бараа материалын худалдан авалтын төлбөрийн баримттай холбоотой зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй, тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Тайлант онд ЗДТГ-ын дарга Г.Бямбадалай, Санхүүгийн албаны дарга А.Оюунтөгс, ЗДТГ-ын нягтлан бодогч Д.Удвалцэцэг нарын ажлыг улирал бүр дүгнэж ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр тооцож олголгүйгээр Засаг даргын 2022 оны А/108 дугаар захирамж, ЗДТГ-ын даргын 2022 оны А/22 дугаар тушаалаар тус 3 албан хаагчид 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр 1 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн урамшуулалд нийт **2,764.8** мянган төгрөгийг олгох шийдвэр гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3 : “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх “Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 3 дугаар хавсралтын 2.2-д “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна” гэсэн заалтуудтай нийцээгүй бөгөөд мөнгөн урамшууллыг давхардуулан олгох эрсдэлийг үүсгэж байна.

Иймд улирлын ажлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан урамшуулал олгох шийдвэр гаргахгүй байх, улирлын үр дүнгийн урамшууллыг албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрүүлэн олгохгүй байх нь зүйтэй юм.

2. Ковид-19 цар тахал болон малын гоц халдварт шүлхий өвчний үед шуурхай штабт ажилласан илүү цагийн бүртгэлийг баталгаажуулалт хангалтгүй байна.

Цаашид илүү ажилласан цагийн бүртгэлийг бүрэн хөтөлж, ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3.1 дэх “Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ.” гэсэн заалтыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

3. Орон нутгийн төсвийн орлого, үүнээс хүү торгуулийн орлогыг тооцоо судалгаанд үндэслэн бодитоор бус хэт өндрөөр төлөвлөснөөс шалтгаалан нийт төсвийн орлогын төлөвлөгөөг **22,575.2** мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5:1 дэх “... төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална.”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Цаашид төсвийн орлогыг, үүнээс хүү торгуулийн орлогыг бодит байдалд үндэслэн үнэн зөв төлөвлөсөн эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй юм.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт **15,091.6** мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 1,145.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 11,653.2 төгрөгийн албан шаардлага, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2,293.4 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлэв.

### **5.1 Төлбөрийн акт**

1. ЗДТГ нь багийн Засаг дарга болон ЗДТГ-ын нийт 16 албан хаагчийн гар утасны зардалд төсвөөс **1,145.0** мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-дэх “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.1: “Гар утасны зардал” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: **1,145.0** мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5.2 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд ЗДТГ-нь **8,450.8** мянган төгрөг, бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтийг тусгасан цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант онд төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас нийт **1,160.4** мянган төгрөгийн авлага үүссэн байна Үүнд:

- ЗДТГ НДШ-ийн тайлангаар 968.2 мянган төгрөгийн илүү төлөлтэй тайлагнасныг санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй,
- ИТХ нь цалингийн тооцооллыг хянаагүйгээс НДШ, ХХОАТ-т 192.2 мянган төгрөгийг илүү шилжүүлэн авлага үүсгэсэн,

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-дахь “...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, өр, авлагыг бүрэн тусгаж, харилцагч байгууллага, иргэнтэй тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж байх албан шаардлага хүргүүлэв.

3. ИТХ нь ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас цалингийн зардалд **2,042.0** мянган төгрөгийг гүйлгэн зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай

хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх шаардлагатай тохиолдолд дээд шатны төсвийн захирагчаас зөвшөөрөл авч төсөвт зохицуулалт хийж байх албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

1.1.Илрүүлэлт: ОНЕО-ын дансанд 2010-2011 онд үүссэн бөгөөд эзэн холбогдогч тодорхойгүй итгэлийн зээлийн 2,293.4 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “*төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-дахь “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*”, 20.2.6-дахь “*...бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2.Зөвлөмж нь: Насжилт өндөртэй итгэлийн зээлийн 2010-2011 оны гэрээг архиваас шүүж эзэн холбогдогчийг тогтоон, барагдуулах арга хэмжээ авах зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ЗДТГ нь багийн Засаг дарга болон ЗДТГ-ын нийт 16 албан хаагчийн гар утасны төлбөр барагдуулсан	1	1,145.0	1	1,145.0								
ИТХ нь НДШ-ийн зардлаас цалингийн зардалд зориулалт бусаар зарцуулсан	1	2,042.0			1	2,042.0						
Тайлант онд төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас авлага үүсгэсэн.	1	1,160.4			1	1,160.4						
Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр давтан гаргасан.	1	8,450.8			1	8,450.8						

Он дамжсан 2010-2011 онд үүссэн итгэлийн зээлийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй.	1	2,293.4					1	2,293.4				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>15,091.6</b>	<b>1</b>	<b>1,145.0</b>	<b>3</b>	<b>11,653.2</b>	<b>1</b>	<b>2,293.4</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Өмнөх оны аудитаар албан шаардлага өгсөн зөрчлийг давтан гаргаж ЗДТГ нь огт мэдээлээгүй 2, хугацаа хоцроон байршуулсан 39 мэдээлэл байна.	41				41			
ИТХ нь өмнөх оны аудитаар албан шаардлага өгсөн зөрчлийг давтан гаргаж, 15 мэдээллийг хугацаа хоцроож, огт мэдээлээгүй 11 мэдээлэл байна	26				26			
<b>Дүн</b>	<b>67</b>				<b>67</b>			
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</b>								
ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг гүйцэтгэх байгууллагатай гэрээ байгуулахдаа урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулаагүй санхүүжилтийн 30-70 хувийг урьдчилж олгосон.	1	59,822.7					1	59,822.7
Захиргааны актыг боловсруулахдаа эрх зүйн үндэслэлийг буруу сонгосон, тэтгэмж олгохтой холбоогүй заалт болон ИТХ-ын ажлын албаны хурлын нарийн бичгийн даргын төсөв захиран зарцуулах эрхийг зөрчсөн байна.	1	890.0					1	890.0
ЭБАТ-ын нэмэгдлийг хөрөнгө орлогын мэдүүлэгч гаргагчийн тоонд харгалзуулалгүйгээр олгосон.	1						1	
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>60,712.7</b>					<b>3</b>	<b>60,712.7</b>
<b>Нийт дүн</b>	<b>75</b>	<b>75,804.3</b>	<b>1</b>	<b>1,145.0</b>	<b>70</b>	<b>11,653.2</b>	<b>4</b>	<b>63,006.1</b>